МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 10 өдөр Дугаар А/165 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, сэргээх тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 15 дугаар зүйлийн 15.12.2, 15.12.3, 15.12.9, 15.12.11, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагуудын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах байгууллагуудын нэрсийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийн эрх сэргээсэн байгууллагын нэрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинэ болон нэмэлтээр авсан, эрх сэргээсэн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Энхболд/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Ламбаа /-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНБААТАР

080585

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 09 сарын 19 өдрийн
А/445 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Бюти Лайф ХХК-ний “Ханна” эмнэлэг	арьс гоо заслын тусламж үйлчилгээ	3 жил
2	Медлайн групп ХХК-ний “Пойнт” эмнэлэг	шүд, арьс гоо заслын тусламж үйлчилгээ	3 жил
3	Дөрвөн цацраг ХХК-ний “Гоёл дент” эмнэлэг	шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээ	3 жил
4	Брилианс клиник ХХК-ний “Брилиант хоспис” эмнэлэг	хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, 10 ортой /амбулатори, гэрээр, хэвтүүлэн эмчлэх/, лаборатори, дүрс оношлогоо	3 жил
5	Мөнгөн марал ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
6	Далхас ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
7	Доктор Аэр ХХК	эм импортлох, ханган нийлүүлэх	3 жил
8	Дорнод Монгол Полимет ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 10 өдрийн
А/165 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Баянголмед ХХК	эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Саба трейд ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил



Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 10 өдрийн
А/165 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СЭРГЭЭСЭН БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Амуулай ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил